


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

“ХҮ1.6. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтээс удаашралтай байгаа болон хэрэгжиж эхлээгүй арга хэмжээнүүдийг 2018 онд багтаан хэрэгжүүлж дуусгахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР